| | | |
|---|---|---|
| - БАТЛАВ.<br>“МИШЭЭЛ ЭКСПО” ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Б.БАЯНДАЛАЙ<br><br>...................................................... | МИШЭЭЛ ЭКСПО<br>ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ТӨВ | ХАЯГ: “МИШЭЭЛ ЭКСПО” ХХК-ИЙН БАЙР, ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ-17, ХАН-УУЛ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО, УЛААНБААТАР 17043<br>ЦАХИМ ХАЯГ: www.misheelexpo.mn<br>ДАНСНЫ ДУГААР:<br>ХААН БАНК<br>₮ 5040 123 789<br>$ 5040 049 703 |

**“МИШЭЭЛ ЭКСПО” ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ТӨВД**
**2023.03.31-04.03 ХООРОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ**
**“УБ БАРИЛГА-2023” ЦУВРАЛ ҮЗЭСГЭЛЭНГИЙН**
**ОРОН СУУЦ, АМИНЫ ОРОН СУУЦ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЗЭСГЭЛЭНГИЙН**
**ТАЛБАЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ**
**№ А1-05-…/23**

.......... ОН ......... САР......... ӨДӨР

| | | |
|---|---|---|
| **ТҮРЭЭСЛЭГЧ ТАЛЫН МЭДЭЭЛЭЛ** | | |
| Байгууллага/ Иргэний нэр: | | |
| Байгууллага/ Иргэний | ☐☐☐☐☐☐☐☐☐☐☐☐☐☐ | регистрийн дугаар: |
| Хаяг: | | |
| Утас: | Факс: | E-mail: |
| Үйл ажиллагааны чиглэл: | | |
| Байгууллагыг төлөөлж: | Нэр: | Албан тушаал: |
| **ЗАХИАЛГА** | | |
| Талайн код: | Нийт талбай: | Нийт үнэ: |
| | | |
| Худалдааны зорилго: | | |
| Бүтээгдэхүүний төрөл: | Бүтээгдэхүүний нэр: | |
| **СТЭНД ҮЙЛЧИЛГЭЭ:** | | |
| Стандарт стэнд түрээслэх ☐ | Захиалгаар стэнд хийлгэх ☐ | |

## 1. ТӨЛБӨР

1.1 Түрээслэгч тал гэрээ байгуулсан өдөр талбайн баталгаажуулалт болгон нийт төлбөрийн 50%-100%- ийг түрээслүүлэгч талд төлнө. Үлдэгдэл төлбөрийг үзэсгэлэн худалдаа буухаас 5 хоногийн өмнө төлж барагдуулсан байна.

Баталгаажуулалтын төлбөр: үнийн дүн ..............................₮, төлсөн өдөр 2023 он ...... сар .......

Эцсийн төлбөр: үнийн дүн ..............................₮, төлөх өдөр 2023 он ...... сар .......

1.2 Түрээслэгч тал нь түрээсийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд гэрээний нийт дүнгээс хэтэрсэн хоног тутам 0.3% алданги тооцно, эсвэл үзэсгэлэн худалдааг цуцална.

1.3 Түрээслэгч тал гэрээнд заасны дагуу түрээсийн төлбөрөө төлсний дараа буюу үзэсгэлэн эхлэхээс өмнө гэрээг цуцлах, оролцох боломжгүй болсон тохиолдолд түрээсийн төлбөрт төлсөн мөнгийг

түрээслүүлэгч тал буцаан олгохгүй.

1.4 Түрээслүүлэгч тал гэрээг цуцлах, тухайн үзэсгэлэнг зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд түрээслэгч талд түрээсийн төлбөрийг буцаан олгоно.

## 2. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Үзэсгэлэнгийн танхимын дотор болон гадна талбайн гэрэлтүүлэг, зам талбайг хэвийн байлгаж /үзэсгэлэнгийн өмнөх өдрийн 19:00 цагаас маргааш өглөөний үзэсгэлэн худалдаа нээгдэх 11:00 цаг хүртэл/ харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

2.2 Түрээсийн төлбөрийг 100% төлөөгүй түрээслэгчийг үзэсгэлэн худалдаанд оролцуулахгүй байх эрхтэй.

2.3 Түрээслэгчийн үзэсгэлэнгийн танхимыг тохижуулах, бэлтгэл ажлаа хангахад нь зориулж үзэсгэлэн худалдаа эхлэхээс өмнө түрээсийн талбайг чөлөөлсөн байна.

## 3. ТҮРЭЭСЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Түрээслэгч тал нь тухайн үзэсгэлэн эхлэх өдрийн өмнөх өдрийн 19:00 цаг, эсвэл тохирсон цагт өөрийн захиалгат талбайн тохижилтыг бүрэн дуусгаж, үзэсгэлэнд ашиглах бараа бүтээгдэхүүнийг байршуулсан байна. Хэрэв дуусгаагүй тохиолдолд хэтрүүлсэн 1 цаг тутамд 50000 /тавин мянга/ төгрөгөөр тооцож түрээслүүлэгч талд торгууль төлнө.

3.2 Үзэсгэлэн нээгдэхээс 1 цагийн өмнө олон нийтэд үйлчлэхэд бэлэн болсон байх үүрэгтэй.

3.3 Үзэсгэлэнгийн талбайг ашиглаж эхэлснээс хойш үзэсгэлэнгийн танхимыг чөлөөлөх хүртэлх хугацаанд "Мишээл Экспо" ОУҮХТөвийн холбогдох журам, Монгол Улсын "Галын Аюулгүй Байдлын Тухай Хууль" болон бусад холбогдох тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөж, мөрдөхийг үзэсгэлэнд оролцож байгаа байгууллага, иргэдээс шаардаж, тэдгээрт харилцан хяналт тавих үүрэгтэй.

3.4 Санаатай болон санамсаргүй байдлаар өндөр хүчдэлийн цахилгаан хэрэгсэл холбож, бусад түрээслэгч болон үзэсгэлэнгийн хэвийн үйл ажиллагаанд хохирол учруулбал учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

3.5 Үзэсгэлэнгийн хуваарийн дагуу 11:00-19:00 цаг хүртэлх хугацаанд түрээсийн талбайн болон бараа материалын аюулгүй, бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна. /Энэ заалт нь үзэсгэлэнгийн үргэлжлэх бүх өдрүүдэд хамаарна/

3.6 Өөрийн захиалгат талбайгаас бусад талбай, явган хүний зам дээр аливаа эд зүйлсийг байршуулахгүй байх үүрэгтэй.

3.7 Түрээслэгч нь өөрийн сонгогдсон талбайг бусдад шилжүүлэх, солих, худалдах, давхар түрээслэхийг хатуу хориглоно. Тус заалтыг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.

3.8 Үзэсгэлэнгийн сүүлийн өдөр 23:00 цаг, эсвэл урьдчилан тогтсон цагт багтаан үзэсгэлэн худалдааны төвийн дотор, гадна талбайг бүрэн чөлөөлнө.

3.9 Үзэсгэлэн худалдааны танхимд овор хэмжээ их, хүнд даацын бараа бүтээгдэхүүн, машин механизм оруулахгүй байх ба зайлшгүй тохиолдолд түрээслүүлэгч талтай зөвшилцөж холбогдох зөвшөөрлийг бичгээр авна.

## 4. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

4.1 Байгалийн гамшиг */үер ус, газар хөдлөлт, улс орныг хамарсан халдварт өвчин гэх мэт/,* олон нийтийг хамарсан үймээн самуун, дайн байлдааны нөхцөл байдал үүссэн тохиолдолд үүнээс үүдэн гарах хохирлыг талууд хариуцахгүй.

## 5. БУСАД ЗҮЙЛ

5.1 Түрээслэгч нь аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний эхийг үзүүлж, 2 талыг нь хуулбарлан гэрээнд хавсаргана.

5.2 Телевиз, хэвлэлийн сурталчилгаанд “Мишээл Экспо” ХХК- ний нэрийг ашиглах шаардлагатай тохиолдолд зөвхөн (“Мишээл Экспо” Олон Улсын Үзэсгэлэн Худалдааны Төв) гэсэн нэрийг ашиглана. Хэрэв энэ заалт зөрчигдөж, “Мишээл Экспо” ХХК- ний нэр олон нийтийн сурталчилгаанд дээр зааснаас өөрөөр ашиглагдвал 500000 /таван зуун мянга/ төгрөгний торгууль оногдуулна.

5.3 Телевиз, хэвлэлийн сурталчилгаанд “Мишээл Экспо” ХХК- ний логог ашиглах шаардлагатай тохиолдолд зөвхөн (“Мишээл Экспо” Олон Улсын Үзэсгэлэн Худалдааны Төв) гэсэн стандарт логог ашиглана. Уг логоны эхийг дижитал хэлбэрээр хүлээн авч хэрэглэнэ. Хэрэв энэ заалт зөрчигдөж, “Мишээл Экспо” ХХК- ний нэр олон нийтийн сурталчилгаанд дээр зааснаас өөрөөр ашиглагдвал 500000 /таван зуун мянга/ төгрөгний торгууль оногдуулна.

5.4 Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу үзэсгэлэн худалдаанд оролцож буй хувь хүн болон хуулийн этгээд нь НӨАТ- ын төлбөрийн баримт олгох постерминал машин хэрэглэх ёстойг анхаарч ажиллана.

5.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн дагуу шаардлага, стандартыг мөрдөж ажиллана.

5.6 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг авч хадгална.

5.7 Энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

5.8 Гэрээг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд маргаан үүсвэл хамтран зөвшилцөж шийдвэрлэнэ. Хэрэв талуудын маргааныг шийдвэрлэж эс чадвал холбогдох хууль хяналтын байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.

5.9 Гэрээний хавсралт болон стенд ашиглах зааварчилгаа нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

| **“МИШЭЭЛ ЭКСПО” ХХК** | **ТҮРЭЭСЛЭГЧ ТАЛ** |
|---|---|
| “МИШЭЭЛ ЭКСПО” ХХК-ИЙН ҮЗЭСГЭЛЭНГИЙН АХЛАХ МЕНЕЖЕР<br><br>...................................................... З.ОДОНТУЯА | ............................................................................- Г ТӨЛӨӨЛЖ:<br><br>НЭР: ..........................................................................................<br><br>ГАРЫН ҮСЭГ: ...................................................................<br><br>ТАМГА: |
| | |

1. **СТЕНД ЗАСУУЛАХ ЭСЭХ:**

ТИЙМ: ________________________

ҮГҮЙ:_________________________

2. **ТИЙМ БОЛ СТЕНД ХАЯГЖИЛТЫН НЭР:**

_______________________________________________________________________________

3. **Жич: info@misheelexpo.mn хаягаар байгууллагын лого болон брэндийн логогоо 2023.02.27-ны дотор илгээнэ үү!**

4. **Үзэсгэлэнгийн ШИЛДЭГ болох номинациудад нэр дэвшүүлэхээр бол ажлын хэсэгт хандан материалаа бүрдүүлэн 2022.03.15-ны дотор материалаа битүүмжлэн ирүүлнэ үү.**

**НОМИНАЦИУД:**

1. ДЭВШИЛТЭТ ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭГЧ,
2. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ,
3. ШИЛДЭГ ОРОН СУУЦ- БАРИЛГА УГСРАЛТЫН БАЙГУУЛЛАГА,

**ТУСГАЙ ШАГНАЛ:**

4. ҮЗЭСГЭЛЭНГИЙН ШИЛДЭГ ТОХИЖИЛТТОЙ БАЙГУУЛЛАГА,
5. БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ НОГООН ТЕЕХНОЛОГИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА,

Хавсралт 1 Танилцаж зөвшөөрсөн: ....................................................

# ХАНАН ХААЛТ БУЮУ СТЭНД АШИГЛАХ ЗААВАР

1. Стендийг цоолох, өрөмдөх, мөн хавтан дээр 20 кг-аас дээш хүнд зүйл өлгөхийг хатуу хориглоно.
2. Стендэд ямар нэгэн зүйл тогтоохдоо силикон буун цавуу, зориулалтын цаасан наалт ашиглана уу.
3. Стендийг үзэсгэлэн дууссаны дараа үзэсгэлэн хариуцсан зохион байгуулагчид анх хүлээн авсан байдлаар албан ёсоор хүлээлгэн өгнө.
4. Стендийн байршлыг өөрчлөх тохиолдолд “үзэсгэлэн зохион байгуулах комисс”-т мэдэгдэн, “мишээл экспо” оуүхтөвийн зохион байгуулагчийн зөвшөөрлийг урьдчилан авна.
5. Стендийг ямар нэгэн байдлаар гэмтээх /өнгө, хэлбэрийг өөрчлөх, цоолох, сэтлэх, хугалах зэргээр бүрэн бүтэн байдлыг алдагдуулах/ тохиолдолд үнийг 3 нугалж түрээслүүлэгч талаар төлүүлнэ.
6. Стэндийг өөрсдөө тохижуулан оролцож байгаа байгууллагууд сүүлийн үеийн шинэлэг технологи ашиглан стэндээ тохижуулахдаа шавар, цемент, тоосго гэх мэт барилгын материал ашиглахгүй байхыг анхааруулж байна.
7. Хүчдэл ихтэй цахилгаан хэрэгсэл зайлшгүй залгах тохиолдолд “мишээл экспо” оуүхтөвийн зохион байгуулагч, цахилгааны инженерийн зөвшөөрлийг авч тус төвийн цахилгаанчнаар холболт хийлгэнэ.
8. Зөвшөөрөгдсөнөөс бусад газар ахуйн цахилгаан хэрэгсэл ашиглахыг хориглоно.
9. Хог, хаягдал зүйлсийг зориулалтын хогийн цэгт хаях.
10. Шалан дээр ямар нэгэн зүйл наахыг хориглоно.
11. Стендний хаалт, хогын сав, разетикийг үзэсгэлэн дуусахад хүлээлгэж өгөх.
12. Оролцогч байгууллагын хаягыг сайн чанарын автостикерээр хийх.


| | | |
|---|---|---|
| Үзэсгэлэнгийн менежер | П. Оюун | утас: 88077036 |
| Цахилгаанчин: | Б. Олзхүү | утас: 99056901 |
| Харуул хамгаалалт: | | утас: 88065894 |